

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2026 оны 06 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зардал (төгрөг)	Хэрэгжих хугацаа	Биелэлт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1	1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг дараах хэлбэрээр олон нийтэд хүргэнэ: -газрын албан ёсны цахим хуудас; -сошиал суваг; -мэдээллийн самбар; -дотоод сүлжээ;	-тогтмол шинэчлэн байршуулсан байх; -хүрсэн үр дүнг тухай бүр тайлагнах; -тайланд нотломжийг хавсаргах;	-	Жилдээ	Тайлант хугацаанд “ТАНЫ МЭДЛЭГТ” тэргүүтэй 5 цуврал постер, мэдээллийг бэлтгэн газрын вэб сайт (https://invest.ub.gov.mn/), Facebook хуудас (https://www.facebook.com/nkhog), мэдээллийн самбараар дэмжуулан мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэж ажиллав. (хавсралт №1)	100 хувь
		1.2. Газрын үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, шүгэл үлээхийг сурталчлан ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	-нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байх; -тайланд нотломжийг хавсаргах;	100.000	Жилдээ	Тайлант хугацаанд энэ чиглэлийн ажил зохион байгуулагдаагүй. Тус ажлыг ажилтнуудыг хамруулан гуравдугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн. Цаашид бусад байгууллагаас зохион байгуулсан нөлөөллийг арга хэмжээг дэмжин ажиллана.	---
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10” тусгай дугаарыг оруулан постер мэдээлэл бэлтгэн дараах хэлбэрээр олон нийтэд хүргэнэ: -газрын албан ёсны цахим хуудас; -сошиал суваг; -мэдээллийн самбар;	-мэдээлэл авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; -мэдээллийг баталгаат эх сурвалжаас авсан байх; -авлигыг мэдээлэх 11-10 тусгай дугаарыг сурталчилсан байх; -нийтэд түгээсэн байх -тайланд нотломжийг хавсаргах;	-	Жилдээ	Авлигатай тэмцэх газрын ашиглаж буй авлигыг мэдээлэх 110 тусгай дугаар 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 11-10 болж өөрчлөгдсөн. Иргэн, албан хаагчид авлигыг мэдээлэх шаардлагатай үед 11-10 тусгай дугаарт холбогдох боломжтой тэргүүтэй мэдээллийг бэлтгэн түгээв. Тайлант хугацаанд Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10” тусгай дугаарыг оруулан бэлтгэсэн 3 постер мэдээллийг газрын вэб сайт (https://invest.ub.gov.mn/), Facebook хуудас (https://www.facebook.com/nkhog),	100 хувь

						мэдээллийн самбарт тус тус нийтлэн олон нийтэл хүргэв. (хавсралт №2)	
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах	2.1.Ажил, албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт ажилтнуудыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	-шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамрагдсан ажилтны тоо; -тайланд нотломжийг хавсаргах;	-	Жилдээ	Тус ажлыг Сургалт хөгжил, шагнал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран гуравдугаар улиралд ажилтнуудыг хамруулан (95 ажилтан) зохион байгуулахаар төлөвлөсөн болно.	---
		2.2.Авлигын эсрэг давтан сургалтад ажилтнуудыг хамруулах;	-тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	Сургалт хөгжил, шагнал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж нотломжийг хавсаргах болно.	---
		2.3.Дээд газраас зохион байгуулагдсан сургалт, хэлэлцүүлэгт удирдах албан тушаалтан болон ЭБАТ-ыг хамруулах;	-тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	Сургалт хөгжил, шагнал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж нотломжийг хавсаргах болно.	---
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байна; -авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байна; -гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байна; -тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	Тус газар нь Улс, Нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд гэрээний үндсэн дээр хяналт тавьж ажилладаг байгууллага юм. Тайлант хугацаанд манай газраас хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээний холбогдох бүлэгт "Авлигын эсрэг хуульд заасан авлигатай холбогдсон талаар бодит мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй" гэсэн агуулгаар авлигаас ангид байх асуудлыг тусган гэрээ байгуулж ажиллаж байна. Гүйцэтгэгч байгууллагуудтай байгуулж байгаа гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох заалтад гэрээ цуцлах журмын зохицуулалтыг, мөн гэрээг цуцалсны дараах төлбөрийн талаар зохицуулалт тусган гэрээ байгуулж хэвшсэн байна. (хавсралт №3)	100 хувь
		3.2.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн	-газрын даргын тушаалаар төлөвлөгөө батлуулан ажилласан байна;	-	Жилдээ	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Журам батлах тухай" 109 дүгээр тогтоол буюу	

		байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулах, хэрэгжүүлэх;	-сургалт, мэдээлэл авсан байна; -тайланд нотломжийг хавсаргасан байна;			"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг түүвэрлэх төлөвлөж Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/08 дугаар тушаалаар "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-н хүрээнд хэрэгжүүлэх ажлыг батлуулав. Тушаалын танилцуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөний нэгдүгээр улирлын биелэлт 95,9 хувь, хагас жилийн биелэлт 94,9 хувийн гүйцэтгэлтэй тус тус газрын даргад тайлагнав. <i>(хавсралт №4)</i>	94.9 хувь
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх... г.м);	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байна; -Тайланд нотломжийг хавсаргасан байна;		Жилдээ	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн үйлчилгээгээр дамжуулан газраас үйлчилгээ авсан гүйцэтгэгч байгууллагуудын төлөөллийг хамруулан Авлигын эрсдэл ба авлига гарах эрсдэлийг тодорхойлох цахим (QR код) судалгааг авч ажиллав. Авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох судалгаанд 20 гүйцэтгэгч байгууллагыг хамруулсан.судалгааны нээлттэй саналыг түүвэрлэн харуулбал 11 оролцогч дараах саналыг өгсөн, 9 оролцогч саналгүй гэж хариулсан. Саналууд: ➤ Ил тод, нээлттэй ажиллагааг сайжруулах – Байгууллагын үйл ажиллагааг бүх шатанд ил тод, нээлттэй зохион байгуулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх. ➤ Хүнд суртлыг бууруулах – Шат дамжлагыг цөөрүүлж, шаардлагатай бичиг баримтын бүрдлийг энгийн, ойлгомжтой болгох.	85 хувь

						➤ Үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх – Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, өргөдөл, хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлэх. ➤ Шударга ёсыг хангах – Авлига, зөрчилтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагууд шударгаар шийдвэрлэдэг байх. ➤ Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах – Цалин, урамшууллын тогтолцоог сайжруулах талаар санал гаргасан. Баримт бичгийн шийдвэрлэлтийн хугацааг хэрхэн багасгаж, ил тод болгох талаар газрын удирдлагын түвшинд танилцуулах,	
		4.2.Газрын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	-2-оос доошгүйг зохион байгуулсан байна; -хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байна; -тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын худалдааны танхимтай хамтран “Бизнес эрхлэгчдийг дэмжих” жилийн хүрээнд “Барилга, дэд бүтцийн салбарын бизнес эрхлэгчидтэй хийх уулзалт”-ыг газрын асуудал, цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, инженерийн дэд бүтцийн хангамж чиглэлээр 2026 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн хангарди ордны “А” байранд зохион байгуулагдсан. Тус уулзалтад гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл мөн газрын дарга Б.Мөнхбат оролцож, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн даалгаврын хэрэгжилтийг холбогдох газарт 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлэв. (хавсралт №5)	100 хувь
						"Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн үйлчилгээгээр дамжуулан газраас үйлчилгээ авсан гүйцэтгэгч байгууллагуудын төлөөллийг хамруулан цахим (QR код) судалгааг авч Авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл	

		4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах байх;	-бодитой үр дүнг тооцсон байна; -тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	бэрхшээлийг тодорхойлох судалгаанд 20 гүйцэтгэгч байгууллагыг хамруулсан. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголтын үнэлгээний дүнгээс харахад: ➤ 16 хүн авлига өгсөн хүн авлига авсан хүнтэй адил гэм буруутай гэж үзсэн. ➤ 15 хүн авлигын эсрэг шүгэл үлээхийг дэмжсэн. ➤ 9 хүн хандивыг авлига мөн, 9 хүн мэдэхгүй, 2 хүн авлига биш гэж хариулсан. ➤ 10 хүн дүрэм, журмын мэдээллийг ил тод авч чаддаг, 6 хүн заримдаа, 3 хүн авч чаддаггүй гэж үнэлсэн. ➤ 18 хүн албан хаагчид ашиг сонирхлын зөрчил гаргадаггүй гэж хариулсан. Эдгээр үр дүн нь оролцогчдын дунд авлигын эсрэг хандлага, байгууллагын ёс зүй, ашиг сонирхлын зөрчилгүй байдлын талаарх үнэлгээ эерэг байгааг харуулж байна.	100 хувь
		4.5. Шударга байдлын үнэлгээг тодорхойлох асуумжийн хүрээнд авч, үр дүнг хэлтсийн даргад танилцуулах	-Шударга байдлын үнэлгээний дүнд тулгуурлан холбогдох мэдээлэл, зөвлөмжийг ажилтнуудад өгөх -тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	Ажилтнуудын шударга байдлыг үнэлэх асуумжийг авлигын эрсдэлийн индексийн хүрээнд дараах чиглэлээр боловсруулан ажиллаж байна. Үүнд: ➤ Нийт ажилтнууд шударга байдал ➤ Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний ажилтны шударга байдал ... асуумж боловсруулах ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна. Тус асуумжийг ажилтнуудаас гуравдугаар улиралд авч, үр дүнг нэгтгэн хэлтсийн даргад танилцуулан ажиллахаар төлөвлөсөн.	40 хувь

5	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллах	-Газрын www.invest.ub.gov.mn вэб сайтад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг байршуулан ажилласан байна;	-	Жилдээ	Хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг газрын https://invest.ub.gov.mn/ вэб сайтад тогтмол нийтлэн, түгээж ажиллаж байна. Тайлант хугацаанд хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлын 58 мэдээ, барилга угсралт болон зураг төслийн ажлын нэгтгэсэн тайланг нэгдүгээр улирал, хагас жилийн байдлаар байршуулан ажиллав.	100 хувь
		5.2.Улс, орон нутгийн, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээллэх;	-Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны с/49 тушаалаар батлагдсан MNS 7023:2023 стандартыг хэрэгжилтийг хангуулан ажилласан байна;	-	Жилдээ	Барилга байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлагыг хангуулах, зураг төслийг үе шатны дагуу боловсруулах, зөвшилцөх, батлах, магадлал хийхтэй холбоотой 32 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэн, зураг төслийн ажлын гэрээт хугацаанд төлөвлөн, холбогдох хууль, норм ба дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгүүлж, төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавин ажилласан. Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд холбогдох стандарт, норм дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хотын стандарт, нормын хэрэгжилтийг иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулах ажлын хүрээнд манай газар хэрэгжиж буй нийт 568 төсөл, арга хэмжээнээс мэдээллийн самбар байршуулах шаардлагатай 142 төсөл, арга хэмжээнд "MNS 7023:2023 стандартын дагуу самбарыг байршуулан мэдээлэл хүргэн ажиллав. Гүйцэтгэгч байгууллагуудад тус стандартын хэрэгжилтийг хангуулах талаар 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/2918 дугаартай албан бичгийг хүргүүлэв. (хавсралт №6)	100 хувь
		5.3.Газрын хэмжээнд хяналт тавин хэрэгжиж буй улс,				Газраар хэрэгжүүлж буй улс, нийслэл, орон нутгийн төсөв, гадаадын төсөл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга угсралт, тохижилт, инженерийн шугам сүлжээ болон барилга байгууламжийн	100 хувь

		нийслэл, орон нутаг, гадаадын төсөл хөтөлбөр, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, тохижилт, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хэсэгчилсэн болон их засварын ажил буюу бүтээн байгуулалтын ажлын явцын мэдээллийг UB.INVEST аппликэйшнээр дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллах;	-Ажлын үр дүнг нээлттэй мэдээллэн ажилласан байна;	-	Тухай бүр	ажлын явц, бүртгэл, мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх зорилгоор UBINVEST аппликэйшнд бүтээн байгуулалтын ажлын явцын мэдээллийг хяналтын инженерүүд тухай бүр оруулж ажиллав. https://investpro.ub.gov.mn/#/projects системийн гар утасны хувилбар бөгөөд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэдэд нээлттэй, хялбар хүргэх боломжийг бүрдүүлсэн. Тус аппликэйшнээр дамжуулан инженер, техникийн албан хаагчдын хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн явц, үр дүн, холбогдох мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар мэдээлэх ажлыг хэвийн зохион байгуулан ажиллаж байна.	
6	Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд	6.1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг ажил, албан тушаалд томилохгүй байх /2.2.2/	-Хэрэгжилтийг хангаж ажилласан байна;	-	Тухай бүр	Тайлант хугацаанд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг meduuleg.iaac.mn буюу мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем хянуулан Авлигатай тэмцэх газрын дүгнэлтийг үндэслэн томилогдсон 1, хяналт шалгалт хийгдэж байгаа 1 мэдүүлэг хянагдаж байна. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг ажил, албан тушаалд томилсон тохиолдол байхгүй.	100 хувь
		6.2.Төрийн албаны журам, стандарт, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар ажилтны ёс зүйг төлөвшүүлэх /2.1.5/	-Ажилтны Ёс зүй төлөвшүүлэх ажил зохион байгуулж ажилласан байна;	-	Тухай бүр	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ёс зүйн дүрэм”-ийг холбогдох хууль тогтоомжид үндэслэн шинэчлэн боловсруулж, Газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлуулж, дүрмийг газрын дотоод сүлжээнд НХОГ групп болон мэдээллийн самбарт QR болон постер хэлбэрээр бэлтгэн байршуулж, нийт ажилтан, албан хаагч нарт мэдээлэл хүргэж танилцуулсан. Газрын “Ёс зүйн дэд хороо”-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 12-ны	100 хувь

					өдрийн А/09 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас жилийн биелэлтийг нэгтгэн газрын даргад танилцуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 79,4 хувь. Төлөвлөгөөний дагуу ёс зүйн зөрчил, гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын "Хайрцаг"-ийг Газрын мэдээллийн самбарт байршуулан ажилтан, албан хаагч болон иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл хүргэн ажиллаж, тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна. Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолын дагуу "Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ"-г 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд авч, үр дүнг нэгтгэсэн. Үнэлгээний нэгтгэл, зөвлөмжийг Ёс зүйн дэд хорооны даргад танилцуулан, мэдээллийг постер хэлбэрээр бэлтгэн Газрын дотоод сүлжээнд "НХОГ" групп болон мэдээллийн самбарт байршуулж нийт ажилтнуудад танилцуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох дүрэм, журмын талаар танилцуулга, мэдээллийг постер хэлбэрээр бэлтгэж Газрын дотоод сүлжээнд "НХОГ" группд нийт 5 удаа байршуулан албан хаагч нарт мэдээлэл хүргэсэн. Мөн төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтуудад хамруулах ажлыг III, IV улиралд зохион байгуулахаар ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--

		6.3.Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлэх /2.1.4/	-Ажлын үр дүнг нээлттэй мэдээллэн ажилласан байна;	-	Тухай бүр	Чадахуйн зарчимд суурилан дараах ажилтнуудыг томилох ажлыг зохион байгуулав. Үүнд: 1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны Б/72 дугаар захирамжаар Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн дарга Б.Ганзоригийг Газрын даргаар, 2.Газрын даргын 2026 оны Б/57 дугаар тушаалаар Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Зүүн бүсийн Ахлах инженер Санжаасүрэнгийн Баасансүрэнг тус хэлтсийн даргаар томилов. 3.Газрын даргын 2026 оны Б/58 дугаар тушаалаар Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Барилгын хяналтын инженер Хишигсүрэнгийн Энхбаатарыг Зүүн бүсийн Ахлах инженерээр томилов. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай Авлигатай тэмцэх газрын албан бичгийг газрын цахим https://invest.ub.gov.mn/ хаягт байршуулан нээлттэй мэдээллэн ажиллав.	100 хувь
		6.4.Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх /2.5.1/	-Цахим үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна;	-	Тухай бүр	Газраас цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээ байхгүй болно. https://investpro.ub.gov.mn/#/projects систем болон гар утасны хувилбар болох UB.INVEST аппликейшнд газраар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний бүртгэл мэдээллийг тогтмол шинэчлэн иргэдэд хөрөнгө оруулалтын мэдээлэлтэй танилцах боломжоор хангаж ажиллав.	100 хувь
		6.5.Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах /2.5.2/	-Мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулсан байна;	-	Тухай бүр	Тайлант хугацаанд газрын албан ёсны вэб сайт (https://invest.ub.gov.mn/)-д Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хүрээнд нээлттэй, ил тод байршуулахаар заасан 132 мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ажиллав.	100 хувь

7	Нэмэлт ажил	7.1.Газрын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд Хууль, дотоод хяналтын хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх;	-хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ хийсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;	-	Жилдээ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 25/92 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтийг 2026 оны хагас жилийн байдлаар нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/2987 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв. <i>(хавсралт №7)</i>	100 хувь
		7.2.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах;	-Өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлэн ажилласан байна -Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулан ажилласан байх;	-	Жилдээ	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/1049 дүгээр журмын хүрээнд Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч ажиллаж байна.Үүнд: 1. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв 2. Хороо бүртгэсэн 3. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв 4. Нийслэлийн лавлагаа мэдээллийн төвийн 1800-1200 тусгай дугаар 5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 7712-0000 тусгай дугаар 6. 131200 тусгай дугаарт мессеж 7. www.eservice.ulaanbaatar.mn цахим хуудас 8. Ухаалаг гар утасны "Check my service" Аппликейшн 9. Фейсбүүк олон нийтийн сүлжээн дэх Газрын invest.ub.gov.mn фейж хуудас 10. Бичгээр болон амаар 11. Газрын 311632 дугаар бүхий суурин утас Тайлант хугацаанд цахимаар болон цаасаар ирсэн 115 өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэн, удирдлагад танилцуулж,	81 хувь

					холбогдох албан хаагчид шилжүүлэн, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэхэд дараах байдлаар хяналт тавин ажиллав. ➤ Өдөрт нь багтаан хүлээн авахыг сануулсан -115 удаа ➤ Өдөрт нь багтаан шилжүүлэхийг сануулсан-115 удаа ➤ Явцын тэмдэглэл хөтлөхийг сануулсан- 130 удаа ➤ Буцаалт 3 хоногт хийхийг сануулсан-5 удаа ➤ Холбогдох файлыг хавсарган, шийдвэрлэхийг утсаар болон биечилсэн хэлбэрээр 92 удаа, нийт давхардсан тоогоор 457 удаа мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, бүртгэл хөтлөн ажиллав.	
	7.3.Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх;	-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо нэмэгдүүлэн ажилласан байна (танхим, цахим)	-	Жилдээ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АЗ шалгалт өгч, гэрчилгээ авах шаардлагатай 6 албан хаагч байгаа бөгөөд шалгалтад бэлтгэх ажлыг зохион байгуулж холбогдох мэдээллийг дотоод сүлжээгээр дамжуулан хүргэж байна. 2026 оны хагас жилийн байдлаар нийт 79 албан хаагч төрийн худалдан авах ажиллагааны гэрчилгээ эзэмшиж байна.	90 хувь
	7.4.Газрын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах;	-Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна;	-	Жилдээ	2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байлаар 3,750,658.11 мянган төгрөгийн орлоготой, 3,545,960.65 мянган төгрөгийн зардалтай 204,697.46 мянган төгрөгийн зардалтай ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж тайлант хугацаанд гарсан нийт зардлын 90 хувь буюу 3,195,504.79 мянган төгрөг нь Цалин, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 10 хувь үйл ажиллаганы зардал эзэлж байна.	100 хувь
					Монгол Улсын Их Хурлын Хууль, зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 5 дугаар тогтоолын дагуу Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд	

		7.5.Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг тогтоосон хугацаанд дээд газарт тайлагнах;	-тайланг хугцаанд байна;	тогтоосон тайлагнасан	-	Жилдээ	хамаарч буй мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын 2025 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг холбогдох хууль, тогтоол, журмын хүрээнд зохион байгуулж Авлигатай тэмцэх газрын https://meduuleg.iaac.mn системийн "Тайлан"-аас хөрвүүлсэн бүртгэл, тайлан, мэдээг зааврын дагуу баталгаажуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн "Тайлан, мэдээ хүргүүлэх тухай" 01/921 дугаар албан бичгээр хүргүүлэв.	100 хувь
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ								94,8

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА


М.ГОВЬСАЙХАН

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ГҮРБАДАМ

НЭГТГЭСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

А.СОЛОНГО



A. Solongor